



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 4/178

Арвайхээр сум

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм батлах тухай" 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Зөвлөлийн дэд дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Зөвлөлийн гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Нийгмийн даатгалын хэлтсийн Үйлчилгээний тасгийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын ангиллын сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн

6223 11 0324

D:My Doc. Zahiramj. Zasag darga



Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, техник хэрэгслэл хариуцсан мэргэжилтэн

Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга  
Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

Аймгийн Ажил олгогч эздийн холбооны дарга

Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн  
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багш

Аймгийн Онги ус суваг орон нутгийн өмчит аж ахуйн  
тооцоот үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн аюулгүй  
байдал, эрүүл ахуйн инженер

Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит  
хувьцаат компанийн Өвөрхангай салбарын хөдөлмөрийн  
аюулгүй байдал эрүүл ахуйн инженер

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын  
Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй  
байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Зөвлөл нь хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж, хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга (И.Доржсүрэн)-д даалгасугай.

3.Дээрх захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай" А/180 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ